

ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ  
(2024-2027)

2026.06.10

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                                      |                                                                                                                                                                                |                                                                                                                                     |               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Зорилго: Нийгмийн салбар, байгууллагын оролцоонд тулгуурлан эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлж, хувь хүн, гэр бүл, хамт олны эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл зан үйл төлөвшүүлэх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                                      |                                                                                                                                                                                |                                                                                                                                     |               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
| Зорилт:<br>1. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх салбар дундын зохицуулалтыг бий болгох<br>2. Бүх шатны боловсролын байгууллагад эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлж, залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл зан үйл төлөвшүүлэх<br>3. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлж, хөдөлмөрийн насны хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл зан үйл төлөвшүүлэх<br>4. Гэр бүл, олон нийт, зорилтот бүлэг, нэг зорилго бүхий сонирхлын бүлгийн хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл зан үйл төлөвшүүлэх<br>5. Эрүүл мэндийн салбарт иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх дэмжлэгт орчин бүрдүүлж, манлайллыг сайжруулах |                                      |                                                                                                                                                                                |                                                                                                                                     |               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
| Хэрэгжүүлэх үйл ажиллагаа                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | Эх үүсвэр                            | Суурь түвшин                                                                                                                                                                   | Зорилтот түвшин, үр дүн<br>(2026 он)                                                                                                |               | Хэрэгжилт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                                      |                                                                                                                                                                                | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт                                                                                                   | Төсөв сая.төг |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
| Зорилт 3. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлж, хөдөлмөрийн насны хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл зан үйл төлөвшүүлэх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |                                      |                                                                                                                                                                                |                                                                                                                                     |               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
| 3.7. “Эрүүл мэндийг дэмжигч биеийн тамир, спортын байгууллага” хөдөлгөөн өрнүүлэх, сургалт, дэмжлэгт хяналт явуулах, үр дүнг тооцох, мэдээлэх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | ОУБ<br>Аймаг,<br>нийслэлийн<br>төсөв | Биеийн тамир, спортын байгууллагад эрүүл мэндийг дэмжигч хөдөлгөөн өрнүүлэх удирдамж төлөвлөгөө боловсруулж батлуулсан байна. Арга зүйн сургалтууд зохион байгуулагдсан байна. | Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болох хөдөлгөөнийг өрнүүлж, шинээр 50 байгууллага эрүүл мэндийг дэмжигч байгууллага болсон байна. | 5,0           | Нийт ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих, дасгал хөдөлгөөнийг өрнүүлэх зорилгоор Эмгэг судлалын үндэсний төв спортын өдөрлөг арга хэмжээг 2026 оны 05 дугаар сарын 17-ны өдөр амжилттай зохион байгуулж, байгууллагын нийт эмч, эмнэлгийн ажилтнууд хамрагдан идэвхтэй оролцлоо. Спортын өдөрлөг арга хэмжээг дартс, гар бөмбөг, сагсан бөмбөг гэсэн гурван төрлөөр амжилттай зохион байгууллаа.                       |
| Зорилт 5. Эрүүл мэндийн салбарт иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх дэмжлэгт орчин бүрдүүлж, манлайллыг сайжруулах                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |                                      |                                                                                                                                                                                |                                                                                                                                     |               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
| 5.1. Эмч эмнэлгийн ажилтнуудын мэдлэг, хандлага, дадалд үнэлгээ хийж, иргэд, үйлчлүүлэгчтэй харилцах харилцаа, зан үйлийн чиглэлээр тулгамдсан асуудлыг тодорхойлох                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | Хариуцах байгууллагын төсөв          | Эмч, эмнэлгийн ажилтнуудын зан үйлийн мэдлэгийн түвшинг тогтоох үнэлгээг жил бүр хийж үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлсэн байна.                               | Төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт хийж, тайлан зөвлөмж боловсруулсан байна.                                                    | 5,0           | Аддиктологийн үндэсний төвөөс архинд донтох эмгэг түүний хор нөлөө сэдвээр 2025.12.22-ны өдөр, Тамхины хэрэглээ, түүний хор нөлөө сэдвээр 2026.02.16-ны өдөр 2 удаагийн сургалт авсан бөгөөд энэхүү сургалтаар байгууллагын эмч, ажилтнуудад хор нөлөө бүхий зан үйлийн эмгэгийн талаар ойлголт мэдлэг олгосон сургалт зохион байгуулсан. Сургалтыг Аддиктологийн үндэсний төвийн эмч О.Баатаржав удирдан явуулсан. |

